



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ 2020 ОНЫ I УЛИРАЛ

АГУУЛГА

I. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах
зээлийн төлөв

8

Хүртээмжтэй
байдал

10

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

12

Ашигт
ажиллагаа

14

Тогтвортой
байдал

16

Бодлого
зохицуулалт

17

II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах
зээлийн төлөв

20

Хүртээмжтэй
байдал

24

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

27

Ашигт
ажиллагаа

29

Тогтвортой
байдал

30

Бодлого
зохицуулалт

31



III. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зах
зээлийн төлөв

34

Хүртээмжтэй
байдал

37

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

40

Ашигт
ажиллагаа

44

Тогтвортой
байдал

46

Бодлого
зохицуулалт

48

IV. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Санхүүгийн зах
зээлийн төлөв

52

Хүртээмжтэй
байдал

54

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

58

Ашигт
ажиллагаа

62

Тогтвортой
байдал

64

Бодлого
зохицуулалт

66

V. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Санхүүгийн зах
зээлийн төлөв

70

Хүртээмжтэй
байдал

71

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

73

Ашигт
ажиллагаа

74

Тогтвортой
байдал

75

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж	ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ХК	Хувьцаат компани
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү	МАРІХ	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МББСБХ	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо	ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
МИК	Монголын ипотекийн корпораци	АFI	Alliance for Financial Inclusion /Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	АТМ	Automated teller machine /Автомат теллер машин/
МХЗХҮХ	Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо	IAIS	International Association of Insurance Supervisors /Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо/
МҮЦБ	“Монголын үнэт цаасны бирж” ХК	IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
ПОС	Карт уншигч төхөөрөмж	FPO	Follow up on public offering /Нэмэлт хувьцаа гаргах/
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо	OECD	The Organisation for Economic Co-operation and Development /Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/
ТДЦА	Татварын дараах цэвэр ашиг		
ТЗК	Тусгай зориулалтын компани		
ҮЦК	Үнэт цаасны компани		
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв		
ХАА	Хөдөө аж ахуй		
ХААДД	Хөдөө аж ахуйн давхар даатгал		
ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү		
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам		

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	Зах зээлийн үнэлгээ 2,489.0 тэрбум төгрөг ЗЗУ/ДНБ 6.7%	Нийт хөрөнгө 350.0 тэрбум төгрөг	ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ
ТОП-20 индекс 16,903.7	Арилжааны хэмжээ 9.6 тэрбум төгрөг	Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж 41.5 тэрбум төгрөг	Нийт нөхөн төлбөр 15.6 тэрбум төгрөг
ХК-ийн тоо 305	Хөрвөх чадвар 0.4%	Цэвэр ашиг 4.6 тэрбум төгрөг	Нөөц сан 157.9 тэрбум төгрөг
MSE A 7,914.1 MSE B 7,660.2	ХАА-н гаралтай барааны арилжааны хэмжээ 28.3 тэрбум төгрөг	Гүнзгийрэлт 0.44%	Нягтрал 60,708 төгрөг
		Давхар даатгалын хураамжийн зардал 13.1 тэрбум төгрөг	

БАНК БУС
САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГА

Тусгай
зөвшөөрөлтэй
540 ББСБ

91.7 %

Зээлийн үйл
ажиллагааны тусгай
зөвшөөрөлтэй

Тусгай зөвшөөрөлтэй
254 ХЗХ

ХАДГАЛАМЖ,
ЗЭЭЛИЙН
ХОРШОО

Нийт хөрөнгө

1.8

их наяд төгрөг

2.2 сая

Харилцагч

Чанаргүй зээлийн
нийт зээлд эзлэх хувь

4.3%

74,701
ГИШҮҮН

Нийт хадгаламж

159.0

тэрбум төгрөг

Цэвэр орлого
2.2 тэрбум төгрөг

Нийт зээл

1.3

их наяд төгрөг

Нийт зээлдэгч

419.9

мянга

Нийт хөрөнгө

229.5

тэрбум төгрөг

НИЙТ ЗЭЭЛ

172.9

тэрбум төгрөг

Зээлийн
жигнэсэн
дундаж хүү

3.0 %

Нийт
орлого **101.8**

Ашиг **41.5**

тэрбум төгрөг

3.1%

Зээлийн жигнэсэн
дундаж хүү

1.5%

Хадгаламжийн
жигнэсэн дундаж хүү



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

2,489.0

тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Данс эзэмшигчид

1,949,760



Хүртээмжтэй байдал

Нийт арилжааны дүн

9.6 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



ҮЦК хөрөнгө

90.2

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



ТОП-20 индексийн
хэлбэлзэл

552.2

Бодлого зохицуулалт




САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



Үнэт цаасны зах зээлд нийт **530** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна

Арилжаа эрхлэх 2	Тооцооны 2	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн 1
ХОМК 25	Арилжаа эрхлэгчдийн холбоо 1	Кастодиан 3
Андерайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 4	ХК 305
ҮЦК* 54	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 14
ҮЦ33-д аудитын үйлчилгээ үзүүлэх 60	ҮЦ33-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 23	ҮЦ33-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 33

*ҮЦК-д брокер, дилер, андерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.




Үнэт цаасны зах зээлийн арилжаа

- 2020 оны 1 дүгээр улиралд нийт 9.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд ЗГҮЦ болон компанийн бондын арилжаа явагдаагүй.
- Үнэт цаасны нийт арилжааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 тэрбум төгрөгөөр буюу 5.2 дахин буурсан.
- Хувьцааны арилжааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.1 тэрбум төгрөгөөр буюу 4.7 дахин буурсан.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 хувиар өсөж 2.5 их наяд төгрөгт хүрсэн бол хөрвөх чадвар 1.4 пунктээр буурч 0.4 хувьд хүрлээ.
- Хөрвөх чадвар буурахад хувьцааны арилжааны хэмжээ 35.1 тэрбум төгрөгөөр буюу 4.7 дахин буурсан нь нөлөөлжээ.



ТОП
20

16,903.7

MSE
A

7,914.1

MSE
Б

7,660.2

Үнэт цаасны зах зээлийн индекс

- **ТОП-20 Индекс** өмнөх оны мөн үетэй харьцуулахад **3,948.6** нэгжээр буюу 18.9 хувиар буурсан.
- **MSE A** индекс өмнөх оны мөн үеэс **1,544.4** нэгжээр буюу 16.3 хувиар буурсан.
- **MSE Б** индекс өмнөх оны мөн үеэс **661.8** нэгжээр буюу 8.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




ХААБ-ээр нийт 28.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 4.9 тэрбум төгрөгөөр буюу 14.7 хувиар буурсан бөгөөд зөвхөн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагджээ.



ХАА-н биржийн МАРИХ индекс

ХААБ-ээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу МАРИХ 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 794,438.0 нэгжид хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 291,371.5 нэгжээр буурсан байна.



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТОП-20 ИНДЕКСТ БАГТАХ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ



ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

- Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 10 ХК-ийн төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 90.1 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн 0.1 хувь нь эзэмшиж байна.



5-аас дээш хувь эзэмшигч

Хувьцааны **90.1%** хувийг **0.1%** нь эзэмшиж байна

5-аас доош хувь эзэмшигч

Хувьцааны **9.9%** хувийг **99.9%** нь эзэмшиж байна



ДАНС ЭЗЭМШИГЧИД



- 2020 оны 1 дүгээр улиралд 122,036 данс нээгдэж нийт дансны тоо 1,949,760-д хүрсэн бол 20,812 холболтын данс нээгдэж холболтын дансны тоо 238,687 – д хүрлээ
- Харин өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 2019 оны 1 дүгээр улиралд нийт нээлгэсэн дансны тоо 1,304,371 байсан бол энэ улиралд 49,5 хувиар нэмэгдэж 1,949,760 болсон.



ДАНС ЭЗЭМШИГЧ


1,949,760

ҮЦТХТ-Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС



ҮЦК БОЛОН ХАА-Н БРОКЕРИЙН КОМПАНИУУДЫН БАЙРШИЛ

- 2020 оны 1 дүгээр улиралд нийт 54 ҮЦК болон тэдгээрийн 33 салбар үйл ажиллагаа явуулав. Эдгээрийг газар зүйн байршлаар харуулбал 59 нь Улаанбаатар хотод, 28 нь орон нутагт байршиж байна.
- 2020 оны 1 дүгээр улиралд нийт 14 ХАА-н брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 10 нь Улаанбаатар хотод, 4 нь орон нутагт байршиж байна.




БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

- 2020 оны 1 дүгээр улиралд нийт хувьцааны арилжаа 9.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 79.4 хувиар буурсан бол 2018 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 46.0 хувиар буурчээ.


Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/



ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

- 2020 оны 1 дүгээр улиралд ЗГҮЦ-ны арилжаа явагдаагүй. Зураглалд 2018 болон 2019 оны 1 дүгээр улирлын арилжааны дүнг харууллаа.

■ ЗГҮЦ-ны арилжаа /тэрбум төгрөг/



КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭСЛИЙН АРИЛЖАА

- 2020 оны 1 дүгээр улиралд компанийн бондын арилжаа хийгдээгүй. Зураглалд 2018 болон 2019 оны 1 дүгээр улирлын арилжааны дүнг харууллаа.

■ Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/



23
ТЗК

81,777
Зээлдэгч

4.3
их наяд
төгрөг

Жимобайл
вексель

7
тэрбум
төгрөг

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС


- Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК-аас 23 ТЗК үүсгэн байгуулж, нийт 81,777 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт

цаасжуулж 4.3 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Хороонд бүртгүүлээд байна.

- Монгол Улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үл хөдлөх хөрөнгийн зээлээр баталгаажуулж ирсэн бөгөөд 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 64,687 зээлдэгчийн 3.0 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаас байна.
- Үүрэн телефоны оператор болох “Жимобайл” ХХК хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан нь үл хөдлөх хөрөнгийн зээлээс өөр төрлийн санхүүгийн хэрэгслээр баталгаасан үнэт цаас гаргасан анхны тохиолдол болсон.

АРИЛЖААНЫ БҮТЭЦ /ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДААР/

- 2019 оны 1 дүгээр улиралд нийт арилжааны дийлэнх буюу 37.7 хувийг гадаадын ААН эзэлж байсан бол 2020 оны 1 дүгээр улиралд гадаадын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ хамгийн бага буюу 1.1 хувь байна.



○ **Дотоодын ААН, 68.4%**


○ **Гадаадын ААН, 1.1%**

○ **Дотоодын иргэн, 27.3%**

○ **Гадаадын иргэн, 3.2%**

ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ

- 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Хорооны үнэт цаасны бүртгэлд нийт 305 ХК бүртгэлтэй байна.
- Өмчийн бүтцийг задлан харвал нийт ХК-ийн 84 хувь нь хувийн өмчит, 10 хувь нь төрийн өмчит, 6 хувь нь төрийн өмчийн оролцоотой компаниуд байна.




○ **Хувийн өмчит 84%**

○ **Төрийн өмчит оролцоотой 6%**

○ **Төрийн өмчит 10%**

АШИГТ АЖИЛЛАГАА




ҮЦК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- o ҮЦК-уудын нийт хөрөнгө 2020 оны 1 дүгээр улиралд 90.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өссөн үзүүлэлт юм.
- o Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 0.6 тэрбум төгрөгөөр буурч, зарлага 0.1 тэрбум төгрөгөөр өсөж, цэвэр алдагдал 0.5 тэрбум төгрөгөөр буурчээ.


ҮЦК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

● Брокерийн үйл ажиллагааны орлого	38.3%
● Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	10.0%
● Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	27.5%
● Хүүгийн орлого	6.3%
● Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого	7.5%
● Бусад орлого	1.6%
● Ногдол ашгийн орлого	6.6%
● Бусад үйл ажиллагааны орлого	0.4%
● Дилерийн үйл ажиллагааны орлого	0.5%
● Түрээсийн орлого	1.4%




ҮЦК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ

● Борлуулалт, маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал	68.0%
● Санхүүгийн зардал	31.8%
● Бусад зардал	0.3%



ХОМК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ХОМК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




ХОМК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХОМК-ийн нийт хөрөнгө 2020 оны 1 дүгээр улиралд 13.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 78.4 хувиар буурчээ.
- Орлого 0.3 тэрбум төгрөгөөр, зарлага 0.4 тэрбум төгрөгөөр, цэвэр алдагдал 1.79 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

ОРЛОГЫН БҮТЭЦ





ЗАРДЛЫН БҮТЭЦ



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ТОП-20 ИНДЕКСИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

- Хувьцааны үнийн хэлбэлзлийг ТОП-20 индексийн хүрээнд тооцон гаргалаа. Хувьцааны үнийн хэлбэлзэл 2020 оны 1 дүгээр улиралд 552.2 нэгж байгаа нь өмнөх оны мөн үеэс 206.7 пунктээр өссөн үзүүлэлт.



MSE A БОЛОН MSE Б ИНДЕКСИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

- Хувьцааны үнийн хэлбэлзлийг MSE A болон MSE Б индексүүдийн хувьд тооцож үзэхэд 2020 оны 1 дүгээр улиралд MSE A индексийн хэлбэлзэл 202.4 пунктээр өсөж, MSE Б индексийн хэлбэлзэл 89.8 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

IPO ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

- 2005 оноос 2020 оны 1 дүгээр улирал хүртэл нийт 27 компани IPO хийж нийт 156.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлээд байна. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар IPO хийгдээгүй байна.



FPO

8
КОМПАНИ

31.6
ТЭРБУМ
ТӨГРӨГ

КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

- Монголд бондын анхдагч зах зээлийн арилжаа анх 2001 онд явагдаж байв. 2001 оноос хойш 2018 он хүртэл давхардсан тоогоор 14 компани 16 удаагийн арилжаагаар нийт 25.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүллээ. 2020 оны 1 дүгээр улиралд компанийн анхдагч зах зээлийн арилжаа идэвхгүй байлаа.

FPO ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

- Монголын анхны Follow on Public Offering (FPO) буюу нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх арилжаа 2007 онд явагдаж байв. 2007 оноос хойш давхардсан тоогоор 8 компани 10 удаагийн арилжаагаар нийт 31.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлжээ. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нэмж хувьцаа гаргасан компани байхгүй байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран "Монгол Улсын Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх" төслийн 2-р үе шатыг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллаж байна.
- Бүгд Найрамдах Казакстан Улсын Астанагийн олон улсын санхүүгийн төвтэй хамтран ажиллахаар бэлтгэл ажил хийгдэж байна.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар "Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг" байгуулагдсан. Үүний хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн төслүүд болон үзэл баримтлалыг боловсруулсан.
- Хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Үнэт цаасны дараа төлбөр тооцооны T+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх тухай" 29 дүгээр тогтоолыг баталсан. Үүний хүрээнд дэд бүтцийн байгууллагуудын холбогдох журмуудыг батламжлах, тусгай зөвшөөрлийг нэмж олгох зэрэг үнэт цаасны зах зээлд төлбөр тооцооны T+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх бэлтгэл ажлуудыг хангаж, дээрх зарчмыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хөрөнгийн зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.
- Хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолоор ногдол ашгийг "ҮЦТХТ" ХХК-аар дамжуулан тараалгах, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах зорилгоор ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоож, Хорооны 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүй болгосон.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран "Монгол Улсын Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх" төслийн 2-р үе шат хэрэгжиж эхэлсэн. Үүний хүрээнд "Компанийн бондын зах зээлийн хөгжил болон зохицуулалтын орчин" сэдэвт хэлэлцүүлгийг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хамтран зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт Хороо, ЖАЙКА-ийн мэргэжилтнүүд, хөрөнгийн зах зээлийн оролцогчид, эдийн засагчид, судлаачид, хөрөнгө оруулагчид, үндэсний томоохон компаниуд, хэвлэл мэдээллийнхэн оролцсон.



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө

350.0 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт
6.8%



Санхүүгийн зах зээлийн төлөв

Даатгалын нягтрал

60,708 төгрөг

Нягтралын өсөлт
8%



Хүртээмжтэй байдал

Зуучилсан даатгалын
болон давхар даатгалын
хураамж

10.3 тэрбум
төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ



Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг
4.6
тэрбум төгрөг



Тогтвортой байдал



Давхар даатгалын
хураамжийн зардал

32.1%

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ



СЗХ–ноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн бүртгэлийн хүрээнд тайлант улиралд нийт 317 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 2,488 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа явуулсан.



* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.

ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2020 оны 1 дүгээр улиралд даатгалын гүнзгийрэлт 0.44 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.01 хувиар буурсан байна.




ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөж, өмнөх улирлаас 4.3 хувиар буурч 350 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад 15.1 хувиар өсөж 286.4 тэрбум төгрөг хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.4 хувиар буурч, 54.1 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 15.5 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улирлаас 1 давхар даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор нийт хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өсөж, 9.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.7 хувийг эзэлж байна.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БҮТЭЦ /НИЙТ ХӨРӨНГӨӨР/

Даатгалын компаниудыг нийт хөрөнгөд эзлэж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 3 даатгалын, 6–9 хувийг 4 даатгалын, 3–6 хувийг 4 даатгалын, 3 хувиас доош хувийг 6 даатгалын компани бүрдүүлж байна.

Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь




ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2019 оны 1 дүгээр улиралд 19.3 хувь байсан бол тайлант улиралд 6.5 хувьтай байна. Харин хөрөнгийн өсөлтөөр бүлэглэвэл 30 хувиас дээш өсөлттэй 3, 20–30 хувийн өсөлттэй 1, 10–20 хувийн өсөлттэй 6, 10 хувиас доош өсөлттэй 5, нийт хөрөнгийн хэмжээ буурсан 2 компани байна.

2019.I/2020.I



- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 оны 1 дүгээр улиралд нийт 40.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 40.3 тэрбум төгрөг буюу 99.1 хувь, урт хугацааны даатгалын компани 0.4 тэрбум төгрөг буюу 0.9 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 13.1 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 0.8 тэрбум төгрөг буюу 5.9 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2020 оны 1 дүгээр улирлын ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.2 хувиар өсчээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 оны 1 дүгээр улиралд 15.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 24.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.1 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 2.9 дахин өсөж 1.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.



НӨӨЦ САН

- Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ тайлант улиралд өнгөрсөн оны мөн үеэс 11.4 хувиар өсөж 157.9 тэрбум төгрөгт хүрсэн.
- Тайлант улиралд ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.5 хувиар өсөж 129.3 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 12.4 хувиар өсөж 2.4 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 1.6 хувиар өсөж 26.1 тэрбум төгрөг болов.

157.9
Тэрбум төгрөг
2020.I

141.8
Тэрбум төгрөг
2019.I



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ДААТГАЛЫН НЯГТРАЛ



Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцох боломжгүй юм. Иймд 2019 оны жилийн эцсийн байдлаар үзүүллээ.


ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 0.3 сая даатгалын гэрээ байгуулагдсан байна. Үүнээс 83.6 хувь нь буюу 274,788 хувь хүнтэй байгуулсан даатгалын гэрээ 16.4 хувь буюу 53,933 хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ байв.

ХУВЬ ХҮН **274,788**
ХУУЛИЙН ЭТГЭЭД **53,933**



Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын нийт 2,268 салбар, төлөөлөгчийн газар 21 аймагт байршиж байна. Эдгээр салбарыг бүсээр ангилвал хангайн бүсэд хамгийн их буюу 723, төвийн бүсэд 687, баруун бүсэд 568, зүүн бүсэд хамгийн бага буюу 290 салбар, төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна.



ТӨЛӨӨЛӨГЧИД

497

626

540

239

- Тайлант хугацаанд Улаанбаатар хотод нийт даатгалын компанийн 54, зуучлагчийн 177, хохирол үнэлэгчийн 38 салбар Хороонд бүртгэлтэй байна.
- Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92.9 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.
- Түүнчлэн Хороонд бүртгэлтэй даатгалын компанийн төлөөлөгчийн газар 12 байгаагаас БНСУ болон БНХАУ–д тус тус нэг төлөөлөгчийн газар байна.



ДААТГАГЧ	СОНГИНО ХАЙРХАН	ЧИНГЭЛТЭЙ	СҮХБААТАР	БАЯНЗҮРХ	
	ЗУУЧЛАГЧ	5	10	13	6
	ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	14	33	43	29
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	ХАН-УУЛ	БАЯНГОЛ	НАЛАЙХ	БАГАНУУР	
	8	5	3	7	
	4	27	4	3	
ДААТГАГЧ	БАГАХАНГАЙ				
	ЗУУЧЛАГЧ	1			
	ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	0			

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



o Ердийн болон урт хугацааны даатгалын нийт 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.

Даатгалын нийт хураамж



Даатгалын нөхөн төлбөр




АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамж тайлант улиралд 7.1 тэрбум төгрөгт хүрч, нийт даатгалын хураамжийн 17.5 хувийг эзэлж байна. Нөхөн төлбөрийн хувьд өнгөрсөн оны мөн үеэс 4.2 хувийн өсөлттэй байна.
- Энэ улиралд 5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр албан журмын хэлбэрээр олгосон нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 32 хувийг бүрдүүлжээ.




ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

- 2020 оны 1 дүгээр улиралд даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 10.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өнгөрсөн оны мөн үед 1.9 тэрбум төгрөг байсан бол тайлант улиралд мөн үеэс 212.5 сая төгрөгөөр өсөж 2.1 тэрбум төгрөгт хүрэв.



ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД


- Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт 5,796 хохирлыг 5.9 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт даатгалын хохирол үнэлгээний орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 28.9 сая төгрөгөөр буурч, 236.4 сая төгрөгт хүрэв.



АШИГТ АЖИЛЛАГАА



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Тайлант улиралд даатгалын компаниудын цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 985.6 сая төгрөгөөр буурч 4.6 тэрбум төгрөгт хүрсэн.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 10, 50 хувь хүртэлх өсөлттэй 2, 50–100 хувийн өсөлттэй 1, 100 хувиас дээш өсөлттэй 4 даатгалын компани байна.



ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хохирол нөхөлтийн харьцаа тайлант улиралд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.8 хувиар өссөн үзүүлэлттэй байв.
- Зардлын харьцаа өмнөх оны мөн үеэс 6.4 пунктээр буурч 41.5 хувь болжээ.
- Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант улиралд 3.5 пунктээр буурч 11.0 хувьд хүрлээ.



АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФФИЦИЕНТ

Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2019 оны 1 дүгээр улиралд 3.3 хувьтай байсан бол 2020 оны 1 дүгээр улиралд 0.6 пунктээр буурч 2.7 хувьд хүрлээ. Нийт хөрөнгийн өгөөжийн хувьд 2019 оны 1 дүгээр улиралд 1.7 хувьтай байсан бол 2020 оны 1 дүгээр улиралд 0.4 пунктээр бууран 1.3 хувьд хүрлээ.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Монгол Улсын даатгалын зах зээлийн тулгамдаж буй асуудлын нэг нь валютын ханшийн эрсдэл юм.
- Даатгалын компаниудын дийлэнх нь гадаад улсад давхар даатгуулдаг бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд 1 жилд дунджаар 50 гаруй тэрбум төгрөгийг гадаад улс руу шилжүүлсэн.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал тайлант улиралд даатгалын нийт хураамжийн 32.1 хувьтай тэнцэж байна.

32.1%

Давхар даатгалын зардлын нийт хураамжид эзлэх хувь

- Тайлант улиралд даатгалын компаниудын нийт хөрөнгийн 60.6 хувийг хөрөнгө оруулалт, үүний 87.8 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.
- Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 2020 оны 1 дүгээр улиралд нийт 5.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон байна.


60.6%

Хөрөнгө оруулалтын дүн

Давхар даатгалын хураамж



Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Хүртээмжтэй даатгалын асуудлаарх харилцан мэдлэг, туршлага солилцох сүлжээ буюу MEFIN (The Mutual Exchange Forum on Inclusive Insurance)-ийн хөтөлбөрийн хүрээнд цахим хурал, хэлэлцүүлэгт хамрагдаж хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.
- Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбоо /IAIS/-ны санаачлагын дагуу Ковид-19 өвчний тархалт, хорио цээртэй холбоотойгоор даатгалын салбарт учирч буй эрсдэл, зохицуулалтын байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэж, энэ хүрээнд тус холбооны гишүүн орнууд туршлага солилцож ажилласан.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Хорооны 2020 оны 114 дүгээр тогтоолоор “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг баталсан бөгөөд энэхүү журам хэрэгжсэнээр зах зээлд оролцогч бүр ёс зүйн дүрэмтэй болж, мөрдөн хэвших, хариуцлага тооцох тогтолцоо бүрдэж, зах зээлийн ёс зүйн харилцаа сайжрах ач холбогдолтой юм.
- Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн хүрээнд Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах холбогдох ажлын хэсэгт орж, саналыг хүргүүлж ажилласан бөгөөд уг хуулиудын үзэл баримтлалын төсөл батлагдсан болно.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтад заасан “Зөвлөхөөс бусад үйлчилгээ болон бараа худалдаж авах тендерийн жишиг баримт бичиг”-ийн шинэчилсэн төсөлд тендер шалгаруулахад даатгалын компанийн нөөцийн сангийн хүрэлцээтэй байдал, санхүүгийн болон төлбөрийн чадварын байдал, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, андеррайтингийн туршлага зэргийг харгалзан үзэх шаардлагатайг илэрхийлж, тодорхой саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын даатгалын тендерт даатгалын компаниуд хамрагдаж даатгалын хэлбэрээр оролцохыг дэмжсэнээр даатгалын салбарын орлого тасалдлыг бууруулах боломжтой.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 29 тоот тушаалаар Төрийн байгууллага, Төрийн бус байгууллага, Даатгалын мэргэжлийн холбоодын төлөөллүүд болон Их, дээд сургуулийн багш доктор, профессор зэрэг 12 даатгалын чиглэлээр мэргэшсэн гишүүдээс бүрдсэн “Даатгалын бодлогын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Тус зөвлөлийн нэгдүгээр хурлаар даатгалын бодлого, эрх зүйн орчин, зохицуулалтын чиглэлээр салбар бүрийн төлөөллүүд өөрийн чиг үүргийн хүрээнд 2020 онд хийж, хэрэгжүүлэх ажлын танилцуулгыг хүргэж, санал солилцон цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцсэн юм.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

1.8

их наяд төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Хөрөнгийн өсөлт

27.3%

Дундаж зээлийн хэмжээ

3.0 сая төгрөг

Харилцагч

2.2 сая



Хүртээмжтэй байдал

ЗЭЭЛИЙН ББСБ

91.7%

тэрбум төгрөг

8.3%



Бүтээгдэхүүн үйлчилгээ

ЗӨВХӨН ГАДААД ВАЛЮТЫН
АРИЛЖААНЫ ББСБ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

101.8

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Z индекс

26.1

Чанаргүй зээлийн
эзлэх хувь

8.4%

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

- 2020 оны 1 дүгээр улиралд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 540 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Эдгээрийн 75 буюу 13.9 хувь нь орон нутагт, 465 буюу 86.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.





Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.2 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай, 94.8 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.

5.2%
Гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2020 оны 1 дүгээр улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 381.3 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өсчээ.






ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	1,776.8	100.0%
Эргэлтийн хөрөнгө	1,707.2	96.1%
Мөнгөн хөрөнгө	351.4	19.8%
Зээл /цэврээр/	1,187.7	66.8%
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	9.5	0.5%
Факторингийн тооцооны авлага /цэврээр/	3.4	0.2%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	12.3	0.7%
Бусад хөрөнгө	142.8	8.0%
Эргэлтийн бус хөрөнгө	69.6	3.9%



ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/


Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	1,776.8	100.0%
Өр төлбөр	488.3	27.5%
Санхүүгийн эх үүсвэр	115.2	6.5%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	203.2	11.4%
Бусад эх үүсвэр	13.3	0.7%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	46.5	2.6%
Төслийн зээлийн санхүүжилт	20.6	1.2%
Бусад өр төлбөр	89.5	5.0%
Эздийн өмч	1,288.4	72.5%
Хувьцаат капитал	951.5	53.6%
Бусад өмч	32.8	1.8%
Сангууд	0.9	0.1%
Хуримтлагдсан ашиг/ алдагдал	302.3	17.0%
Хоёрдогч өглөг	0.8	0.0%




Зах зээлд эзлэх хувь хэмжээ буюу нийт хөрөнгөд эзлэх хувиар нь харвал салбарын нийт хөрөнгийн

- 25 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 8 ББСБ;
- 50 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 44 ББСБ;
- 75 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 181 ББСБ эзэлж байна.

Нийт зээл /тэрбум төгрөг/



Зээлийн хүү: 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.0 хувьд хүрч буурлаа.




НИЙТ ЗЭЭЛ

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар буюу 296.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 97.2 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 2.8 хувийг валютаар олгосон зээл эзлэж байна.

97.2%




ХЭВИЙН

87.6%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

4.0%



ЧАНАРГҮЙ

8.4%

Олгосон зээл

Төлөгдсөн зээл

Хэрэглээ



72.0% 70.5%

Бөөний болон жижиглэн худалдаа



9.8% 10.3%

Барилга



5.8% 5.8%

Уул, уурхай олборлолт



1.4% 2.6%

Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ



2.2% 1.9%

Боловсруулах үйлдвэр




1.9% 1.2%

Машин, мотоциклийн засвар үйлчилгээ



1.5% 1.5%


Бусад



6.3% 6.2%

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ


Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй 540 банк бус санхүүгийн байгууллага нийт 273 салбартай байна. Хорооноос зөвшөөрөлтэй 540 банк бус санхүүгийн байгууллагыг зураглалаар харуулвал дийлэнх нь буюу 86.1 хувь нь Улаанбаатар хотод байршилтай байна.



1 000 аж ахуйн нэгжид ногдох



100 000 хүн амд ногдох



Улаанбаатарт үйл ажиллагаагаа явуулж буй 465 ББСБ-ын 35.5 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 30.5 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 15.3 хувь нь Баянгол дүүрэгт, 10.8 хувь нь Баянзүрх дүүрэгт, 6.5 хувь нь Хан-Уул дүүрэгт, 1.3 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

ББСБ-УУДЫН ХҮРТЭЭМЖ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР

- Монгол улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 25 банк бус санхүүгийн байгууллага, 1,000 аж ахуйн нэгжид 26 банк бус санхүүгийн байгууллага ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 10, 5 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд төвийн бүс 100,000 иргэнд 14, 1,000 аж ахуй нэгжид 7 банк бус санхүүгийн байгууллага ногдож байгаагаар банк бус санхүүгийн байгууллагын хүртээмжээр тэргүүлж байна.

Улсын хэмжээнд
100 000 хүнд

25
ББСБ

1 000 аж
ахуйн нэгжид


26
ББСБ




**ДУНДАЖ
ЗЭЭЛ**

- 2020 оны 1 дүгээр улиралд Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 3.0 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 2.9 сая төгрөг, Улаанбаатар хотын хувьд 3.0 сая төгрөгийн зээлтэй байна.
- Харин уг үзүүлэлт өмнөх оны мөн үед улсын хэмжээнд 3.7 сая төгрөг байсан ба тайлант улирлын хувьд банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 1.2 дахин буюу 709.5 мянган төгрөгөөр буурчээ.


Банк бус санхүүгийн байгууллагын харилцагчид



Банк бус санхүүгийн байгууллагын зээлдэгчид /насны бүлгээр/



Банк бус санхүүгийн байгууллагын зээлдэгчид /боловсролын түвшингээр/



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

- 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт орлого 101.8 тэрбум төгрөгт хүрэв.
- Нийт орлогын 97.6 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Үүнээс нийт орлогын 81.3 хувь буюу 82.8 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 16.3 хувь нь буюу 16.6 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.

- Хүүгийн орлого
- Хүүгийн бус орлого
- Үндсэн бус үйл ажиллагааны орлого
- Үндсэн үйл ажиллагааны орлого




- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого
- Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого
- Арилжааны орлого
- Картын үйлчилгээний орлого
- Мөнгөн гуйвуулгын орлого
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого
- Бусад

ХҮҮГИЙН БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА

- Хүүгийн бус орлогын 57.2 хувийг үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, 13.5 хувийг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 7.5 хувийг арилжааны орлого, 2.9 хувийг картын үйлчилгээний орлого, 1.5 хувийг мөнгөн гуйвуулгын орлого, 0.4 хувийг санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого, 16.9 хувийг бусад орлого тус тус бүрдүүлж байна.


- Факторингийн үйлчилгээ гэдэг нь зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүхэлд нь хариуцах үйл ажиллагааг хэлдэг. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын хэмжээнд нийт 3.4 тэрбум төгрөгийн факторингийн цэвэр авлага бүртгэлтэй байна.

Факторингийн үйлчилгээний цэвэр авлага /тэрбум төгрөг/




- Салбарын хэмжээнд тайлант улиралд 38 банк бус санхүүгийн байгууллага уг үйлчилгээг эрхэлж байна.
- Тэдгээрийн үзүүлсэн итгэлцлийн үйлчилгээний нийт өглөг 115.2 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оны мөн үеэс 74.4 хувиар өслөө.

Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөг/



Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого /тэрбум төгрөг/



- 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагууд мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс нийт 242.5 сая төгрөгийн орлогыг олжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 11.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.
- Салбарын хэмжээнд нийт 31 байгууллага уг үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас тайлант улиралд 11 нь уг үйлчилгээнээс орлого олсон байна.

ХУДАЛДСАН, ХУДАЛДАН АВСАН ВАЛЮТЫН МЭДЭЭ



ВАЛЮТЫН НЭР	Худалдаж авсан	Худалдсан
	Дүн /тэрбум төгрөг/	Дүн /тэрбум төгрөг/
АНУ-ЫН ДОЛЛАР	151.7	148.9
БНХАУ-ЫН ЮАНЬ	137.3	144.8
ЕВРО	35.0	33.6
ЯПОНЫ ИЕН	9.8	5.5
БНСУ-ЫН ВОН	8.0	6.8
БУСАД	9.6	5.5

ФИНТЕК




Салбарын нийт зээлийн үлдэгдэлд бага хувь эзэлж байгаа ч олгосон болон төлөгдсөн зээлд злэх хувиас харахад эдгээр банк бус санхүүгийн байгууллагуудын зээл эргэлт сайтай байгаа нь харагдаж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА



ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ББСБ-ын тоо /хувиар/



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА /ХӨРӨНГИЙН АНГИЛЛААР/

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 1 тэрбумаас доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 0.4 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй, 1–2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 1.5 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 3.1 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 0.4, 1.6 болон 3.4 хувьтай байна.


ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА

Банк бус санхүүгийн байгууллагууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог харьцаа болох зардал, орлогын харьцаа тайлант улиралд 44.4 хувь гарсан буюу өмнөх оны мөн үеэс 2.5 нэгжээр өсчээ. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн байгууллагууд 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 44.4 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


- o AFI буюу “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг”-ээс санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох зөвлөмж зааврын дагуу банк бус санхүүгийн байгууллагуудын дараах 4 үзүүлэлтийг тооцож байна. Үүнд:



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХАРЬЦАА


- o Тайлант улиралд уг харьцаа 102.3 хувь гарч байгуулвал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг 102.7 хувиар нөхөх чадамжтайг харуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.

102.7%




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ

Тайлант улиралд чанаргүй зээлийн хэмжээ 106.4 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 8.4 хувь болж буурлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.7 нэгжээр багасав.



ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу хөрвөх чадвар тайлант улиралд 19.8 хувь болжээ.
- 2020 оны 1 дүгээр улиралд мөнгөн хөрөнгийн өсөлт 11.3 хувьтай байгаа нь нийт хөрөнгийн өсөлтөөс 16.0 пунктээр бага байгаа тул хөрвөх чадвар өмнөх оны мөн үеэс 2.8 пунктээр буурчээ.



Z ИНДЕКС

Z индекс нь банк бус санхүүгийн байгууллагын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын Z индекс өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Хорооны зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын мэргэжлийн холбоод болон сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа төслийн зөвлөхтэй уулзалт зохион байгуулж, салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалт, ББСБ-уудыг чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.
- Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсгийн 4 удаагийн семинар хуралд оролцож, “Хүртээмжтэй ногоон санхүү ба тогтвортой хөгжлийн зорилтуудын танилцуулга”, “Уур амьсгал ба гамшгийн эрсдэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх”, “Ногоон санхүүгийн салбар дахь төв банкны үүрэг” зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэг хийсэн.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам” батлах тухай тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, 10 дугаар тогтоолоор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4672 дугаараар бүртгүүлсэн.
- Санхүүгийн зохицуулах хорооноос шинэ төрлийн корона вирус (Covid-19)-ын улмаас дотоодын эдийн засаг, санхүүгийн салбарт эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж эхлээд байгаа энэ үед санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, харилцагч, зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 122/58 тоот хамтарсан тушаалаар өөрчлөлт оруулж, 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх түр хугацаанд хэрэгжүүлж ажиллахаар шийдвэр гаргаад байна.
- Мөн 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 148 дугаар тогтоолоор үүсээд байгаа эдийн засгийн хүндрэлтэй байдлын үед банк бус санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлж банк бус санхүүгийн байгууллагуудын улсын төсөвт жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлдэг зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулах шийдвэрийг гаргасан байна. Ингэснээр харилцагч, зээлдэгчдийнхээ өрийн дарамтыг багасгах боломжийг олгож байгаа юм.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Олон Улсын Санхүүгийн Корпораци болон Олон Улсын Факторингийн Холбоотой хамтран “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт болон факторингийн үйл ажиллагааг хөгжүүлэх нь” сэдэвт ББСБ-уудад зориулсан сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд хамтран зохион байгуулж 70 ББСБ-ын төлөөлөл, арилжааны банкны 10 төлөөлөл, СЗХ-ноос 12 албан хаагчийг хамруулсан.



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

229.5 тэрбум
төгрөг

Хөрөнгийн өсөлт
8.4%



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нийт салбар **61**

Нийт гишүүдийн
45.8%
дээд боловсролтой



Хүртээмжтэй байдал

ХЗХ-дын хэрэглээний зээл
эргэн төлөгдсөн хувь

68.1%



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр орлого

2.2

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Нийт зээлд эзлэх чанаргүй
зээлийн хувь

4.3%


Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ХЗХ–ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ–дын тоо 254–т хүрч өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар буурлаа.
- ХЗХ–дын гишүүдийн тоо 2019 оны 1 дүгээр улиралд 66,296 байсан бол тайлант улиралд 12.7 хувиар өсөж 74,701–т хүрчээ.



АЖИЛЛАГСАД

810

ХЗХ–дын нийт ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувиар нэмэгдсэн бөгөөд түүний 73.1 хувь нь эмэгтэй

НИЙТ ГИШҮҮДИЙН


40,767

ЗЭЭЛДЭГЧ

38,066

ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ ○ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/



НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар өсөж 229.5 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 23.2 пунктээр буурчээ.

НИЙТ ЗЭЭЛ

172.9

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ
ХАДГАЛАМЖ

159.0

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Салбарын нийт хөрөнгийн

- 85.4 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 23 ХЗХ;
- 2.7 хувийг 500 саяас 1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй 9 ХЗХ;
- 11.9 хувийг 500 сая төгрөгөөс доош хөрөнгөтэй 222 ХЗХ эзэлж байна.

85.4% 23 ХЗХ

2.7%
9 ХЗХ

11.9%
222 ХЗХ

ХЗХ-дын актив болон пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	229.5	100.0%
Эргэлтийн хөрөнгө	225.3	98.1%
Мөнгөн хөрөнгө	47.2	20.6%
Зээл /цэврээр/	168.0	73.2%
Авлага	8.2	3.6%
Бусад эргэлтийн хөрөнгө	1.0	0.5%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	0.7	0.3%
Эргэлтийн бус хөрөнгө	4.3	1.9%
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.0	1.7%
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.2	0.1%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.02	0.0%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	229.5	100.0%
Өр төлбөр	186.3	81.2%
Хадгаламж	159.0	69.3%
Богино хугацаат зээл	3.3	1.4%
Бусад богино хугацаат өр төлбөр	16.5	7.2%
Урт хугацаат өр төлбөр	7.5	3.3%
Өөрийн хөрөнгө	43.2	18.8%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18.4	8.0%
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.2	0.1%
Хоршоологчдын өмч	24.6	10.7%



- Нийт хөрөнгийн 98.1 хувь нь эргэлтийн хөрөнгө, үлдсэн 1.9 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.
- Эргэлтийн хөрөнгийн 20.6 хувийг мөнгөн хөрөнгө, 73.2 хувийг зээлийн цэвэр үлдэгдэл, 3.6 хувийг авлагын үлдэгдэл бүрдүүлж байна.
- Эх үүсвэр талын бүтцээс харахад нийт хөрөнгийн 81.2 хувийг өр төлбөр, 18.8 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАРУУН БҮС

39 ХЗХ

8 САЛБАР

ХАНГАЙН БҮС

23 ХЗХ

15 САЛБАР

ТӨВИЙН БҮС

22 ХЗХ

19 САЛБАР

ЗҮҮН БҮС

10 ХЗХ

12 САЛБАР

- Тайлант улиралд нийт 254 ХЗХ-ноос 160 ХЗХ нь нийслэл Улаанбаатар хотод, 94 ХЗХ нь хөдөө, орон нутагт бүртгэлтэй байна.
- Хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 41.5 хувь нь баруун бүсэд, 10.6 хувь нь зүүн бүсэд, 24.5 хувь нь хангайн бүсэд, 23.4 хувь нь төвийн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 160 ХЗХ-дын 93.1 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 6.9 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байршиж байна.
- Багахангай дүүрэгт банкнаас бусад санхүүгийн салбараас зөвхөн ХЗХ үйл ажиллагаа явуулж байна.




“Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)”-ийн Санхүүгийн хүртээмжийн тоон мэдээллийн ажлын хэсгээс улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг¹ 2013 онд гаргасан байдаг. Ажлын хэсгээс гаргасан индикаторуудыг ашиглан доорх байдлаар салбарын хүртээмжтэй байдлыг харуулья. Үүнийг хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд ногдох, 1,000 аж ахуйн нэгж (ААН)-д ногдох ХЗХ-дын тоогоор илэрхийлж болно.

10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



1 000 ААН-д ногдох ХЗХ-ны тоо



- 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор Багануур дүүрэг 6.2, Налайх дүүрэг 6.1 үзүүлэлттэйгээр тус тус тэргүүлж байгаа бол Баянгол дүүрэг 0.4 гэсэн үзүүлэлттэйгээр хамгийн доогуур жагсаж байна.
- Харин 10,000 хүнд ногдох ХЗХ-ны тоогоор Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргүүд тус тус 3.6, 3.4, 3.4 гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байна.

¹ <https://www.afi-global.org/sites/default/files/publications/fidwg-core-set-measuring-fi.pdf>



Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад баруун бүс 10,000 хүнд ногдох, 1,000 ААН-д ногдох ХЗХ-дын тоогоор бусад бүсээс илүү сайн үзүүлэлттэй байна.

Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл



ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 50 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт нь хөдөө, орон нутагт 79 байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 35 байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 4.2 сая төгрөгийн зээлтэй байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 5.5 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 1.8 сая төгрөг байна.


ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 53 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, хадгаламжийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт хөдөө, орон нутагт 61 байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 46 байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-нд хадгаламжтай нэг хадгаламж эзэмшигч гишүүн дунджаар 4.2 сая төгрөгийн хадгаламжтай байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.0 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 1.1 сая төгрөг байна.


Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ




ХЗХ-НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ



НАСНЫ БҮЛГЭЭР



БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР




БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХЗХ–ДЫН ЗЭЭЛ

- Тайлант улиралд нийт зээлийн хэмжээ 172.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өслөө.
- Цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар өсөж 168.0 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 4.1 хувиар өсөж 5.0 тэрбум төгрөгт хүрлээ.

■ Нийт зээл /тэрбум төгрөг/ ○ Зээлийн өсөлт /хувь/



ХЭВИЙН

92.2%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

3.5%



ЧАНАРГҮЙ

4.3%

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЧАНАР

- Тайлант улиралд хэвийн зээл өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөж 159.5 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт зээлийн 92.2 хувийг хэвийн зээл эзэлж байна.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар өсөж 6.0 тэрбум төгрөгт хүрлээ.
- Чанаргүй зээл 22.5 хувиар өсөж 7.4 тэрбум төгрөгт хүрлээ.

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ


- Нийт олгосон зээлийн 86.6 хувь нь хэрэглээнд, 6.0 хувь нь бизнесийн үйл ажиллагаанд, 2.1 хувь нь хөдөө аж ахуйн салбарт олгогдсон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 85.2 хувь нь хэрэглээнээс, 6.4 хувь нь бизнесийн үйл ажиллагаанаас, 1.9 хувь нь хөдөө аж ахуйн салбараас эргэн төлөгдсөн байна.

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ



■ Нийт хадгаламж /тэрбум төгрөг/ ○ Хадгаламжийн өсөлт /хувь/



ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

○ ХЗХ-дын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өсөж 159.0 тэрбум төгрөг боллоо.

НИЙТ ХАДГАЛАМЖ

○ 97.5 хувийг хугацаатай хадгаламж, 2.5 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.



97.5%

ХУГАЦААТАЙ



2.5%

ХУГАЦААГҮЙ



ХАДГАЛАМЖ ТАТСАН

239 ХЗХ



ХАДГАЛАМЖ ТАТААГҮЙ

15 ХЗХ

○ Тайлант улиралд ХЗХ-дын 94.1 хувь буюу 239 нь нийт 159.0 тэрбум төгрөгийн хадгаламжтай.
○ Үлдсэн 5.9 хувь буюу 15 нь хадгаламж татаагүй байна.



НИЙТ ХАДГАЛАМЖИД ЭЗЛЭХ ХУВЬ

- 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 14 ХЗХ нь нийт 137.7 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 86.6 хувийг;
- 100 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай 60 ХЗХ нь нийт 17.2 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 10.9 хувийг;
- 10 саяас доош төгрөгийн хадгаламжтай 180 ХЗХ нь салбарын нийт хадгаламжийн 2.5 хувийг тус тус бүрдүүлж байна.

1.5%

Хадгаламжийн
жигнэсэн дундаж
сарын хүү

3.1%

Зээлийн
жигнэсэн дундаж
сарын хүү

БУСАД ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ХЗХ

2019.1

2020.1

Төслийн санхүүжилтийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ХЗХ

113

102

Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ХЗХ

3

3

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ХЗХ

3

4

Салбарын зөвшөөрөлтэй ХЗХ

7

САЛБАР-27

7

САЛБАР-61

ОРЛОГО

- ХЗХ–дын хүүгийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.0 хувиар өсөж 13.4 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хүүгийн орлогын хамгийн өндөр хувийг буюу 97.4 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна.
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 2.4 хувийг, зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.5 хувийг тус тус эзэлжээ.
- Санхүүгийн түрээсийн орлого 8.5 сая төгрөг байна.



ЗАРДАЛ


- ХЗХ–дын хүүгийн зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өсөж 7.6 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хүүгийн зардлын хамгийн өндөр буюу 97.5 хувийг хадгаламжийн хүүгийн зардал эзэлж байна.
- Хүүгийн зардлын 2.4 хувийг эзэлж буй банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүү өмнөх оны мөн үеэс 28.0 хувиар өсөж 178.2 сая төгрөг болжээ.
- Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал 36.1 хувиар буурч 0.6 сая төгрөгт хүрчээ.




АШИГТ АЖИЛЛАГАА

ХЗХ–ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- Тайлант улиралд нийт ХЗХ–д 14.0 тэрбум төгрөгийн орлого, 11.8 тэрбум төгрөгийн зардал, 2.2 тэрбум төгрөгийн цэвэр орлоготой ажиллалаа.
- Цэвэр орлогын нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос 57.0 пунктээр буурч 15.6 хувьд хүрчээ.



■ Нийт хөрөнгийн өгөөж ■ Өөрийн хөрөнгийн өгөөж





НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

- ХЗХ–дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 пунктээр өсөж 6.4 хувьд хүрлээ.
- Нийт хөрөнгийн өгөөж нь 0.8 пунктээр өсөж 1.1 хувьд хүрчээ.

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Тайлант улиралд гишүүдэд олгож буй зээлийн хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр өсөж 7.8 хувьд хүрлээ.
- Энэхүү үзүүлэлт ХЗХ-дын зээлийн үйлчилгээнээс олж буй дундаж орлогыг харуулдаг тул тайлант онд ойролцоогоор 100 төгрөгийн зээлийн үйлчилгээнээс олсон орлого 8 төгрөг байна.
- Цэвэр орлогыг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц орлогын харьцаа нь өмнөх оны мөн үеэс 8.0 пунктээр өсөж 15.6 хувь болжээ.



ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА


- ХЗХ-д 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 23 төгрөгийн зардал гаргаж байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлт /PEARS аргачлал/-ийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.

■ Чанаргүй зээл /тэрбум төгрөг/ ○ Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь




ХЗХ-ДЫН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Нийт чанаргүй зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 1.4 тэрбум төгрөгөөр өсөж 7.4 тэрбум төгрөг боллоо.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.5 пунктээр өсөж 4.3 хувьд хүрлээ. Энд, ХЗХ-дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 5 хувиас бага байх ёстой.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ


- Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 18.2 пунктээр өсөж 39.2 хувь болжээ.
- Эргэлзээтэй зээлийн хувьд өнгөрсөн оны мөн үеэс 1.5 пунктээр буурч 17.1 хувьд хүрсэн бол муу зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх хувь 43.8 хувь байна.

■ Хэвийн бус зээл ■ Эргэлзээтэй зээл ■ Муу зээл




ХЗХ–ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР:

- ХЗХ–дын нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа тайлант улиралд 20.6 хувьтай байна.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт 75.4 хувьтай байна.



- Зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь
- Зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгөд эзлэх хувь



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН

- Тайлант улиралд ХЗХ–дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурч 2.9 хувьд; харин нийт хөрөнгөд эзлэх хувь 0.1 пунктээр өсөж 2.2 хувьд хүрсэн байна.

Харьцаа	Зохистой хувь	Тайлант улиралд
Бусдаас авсан зээл/Нийт зээл	<20%	6.2%
Нийт хадгаламж/Нийт хөрөнгө	20%–80%	69.3%
Цэвэр зээл/Нийт хөрөнгө	60%–85%	73.2%
Хоршоологчдын өмч/Нийт хөрөнгө	>5%	10.7%
Нөөцийн сан/Хоршоологчдын өмч	>10%	20.8%
Хадгаламж хамгааллын сан/Хоршоологчдын өмч	>5%	6.8%
Тогтворжилтын сан/Хоршоологчдын өмч	>5%	6.8%
Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<15%	1.4%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Санхүүгийн зохицуулах хорооноос Азийн хөгжлийн банктай хамтран 2019–2020 онд “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна.
- Төслийн хүрээнд 2019 оны 5 дугаар сараас 2020 оны 01 дүгээр сард “Хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийн удирдлага” сэдэвт семинарыг зохион байгуулж, МХЗХҮХ-ны 23 сургагч багш, Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 69 хадгаламж, зээлийн хоршооны 197 хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийг хамруулсан.
- Семинарт оролцогчдоор дотоод хяналт, засаглал ил тод байдлын олон улсад мөрдөгддөг шалгах хуудсыг туршилтаар ажиллуулан хадгаламж, зээлийн хоршооны 2019 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийж, тайланг Хороонд ирүүлэхийг даалгасан. Ирүүлсэн тайлангуудтай танилцаж, холбогдох саналыг нэгтгэн, авах арга хэмжээний саналыг боловсруулж байна.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр олон нийтээс санал авах хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хооронд Хорооны цахим хуудсан хуулийн төслийг байршуулж олон нийт болон салбарын оролцогчдын саналыг авсан бөгөөд хуулийн төсөлд шаардлагатай саналыг тусган холбогдох өөрчлөлтийг хийсэн.
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар ББСБ, ХЗХ-ноос олгосон зээлийн ангиллын хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэний дагуу Хорооны дарга, Сангийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 122/58 тоот хамтарсан тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-ын 2.4 “Активын гэрээний хугацааг 1 удаа сунгасан бол ангиллыг хэвээр хадгална, харин 2 болон түүнээс дээш сунгасан бол өмнөх ангиллаас нэг шатлалаар бууруулна” заалт, уг журмын хавсралт “Зээл, санхүүгийн түрээсийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт”-ийн үйлчлэлийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл түр хугацаанд зогсоож, тушаалд заасны дагуу зээлийн авлагыг ангилж ажиллах шийдвэрийг гаргасан.
- Хорооны 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 148 дугаар тогтоолоор ББСБ, ХЗХ-ноос 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулах шийдвэрийг гаргасан. Энэ талаарх мэдээллийг 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Хорооны цахим хуудсаар нийтэлж, цахим шуудангаар нийт хоршоодод мэдээлсэн.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Хорооны дэргэдэх Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийг 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хуралдуулж цаг үеийн нөхцөл байдал, Хорооноос авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, санхүүгийн салбарын өрсөлдөөн болон хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зохицуулалтыг боловсронгуй болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар хэлэлцэж, цаашид салбарын оролцогчид их сургуулиудын төлөөлөлтэй хамтран судалгаа шинжилгээ хийж, холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой асуудлыг Хорооны хуралдаанд танилцуулахаар шийдвэрлэсэн. Хорооны хуралдаанд танилцуулах Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийн зөвлөмжийн төслийг боловсруулсан.
- Монгол Улс 2017 онд Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөл (ICURN)-ийн гишүүн болсон ба тус зөвлөлөөс 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан цахим хуралд оролцож цар тахлын үед улс орнуудын авч буй арга хэмжээний талаарх мэдээлэлтэй танилцсан.



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

109.6
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нэг батлан даалтын
дундаж хэмжээ

242.4
сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Ирүүлсэн
хүсэлтийн тоо **31**

Зөвшөөрөгдсөн
хүсэлтийн тоо **14**



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

1.7 тэрбум төгрөг

Нийт ашиг

1.3 тэрбум төгрөг

Тогтвортой байдал




Чанаргүй батлан
даалтын эзлэх хувь

14.6%



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 109.8 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 54.3 хувиар өслөө.




- Сангийн батлан даалтын үлдэгдэл 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 64.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23.5 хувиар буюу 12.2 тэрбум төгрөгөөр өслөө.
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар буюу 21.7 тэрбум төгрөгөөр өсөж 122.7 тэрбум төгрөгт хүрлээ.



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



НИЙТ БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ





БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	Эзлэх хувь
2017.1	12	9	75.0%
2018.1	109	50	45.9%
2019.1	46	18	39.1%
2020.1	31	14	45.2%


2020 оны 1 дүгээр улиралд батлан даалт гаргуулах нийт 31 хүсэлт ирснээс 14 хүсэлт нь зөвшөөрөгдсөн байна. Ирүүлсэн хүсэлтийн тоо нь өмнөх оны мөн үеэс 1.5 дахин бага байна.



Өмнөх оны мөн улиралд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт батлан даалт түлхүү гаргаж байсан бол тайлант улиралд бөөний болон жижиглэн худалдааны салбарт гаргасан батлан даалт нийт батлан даалтын дийлэнх хэсгийг бүрдүүлж, хөдөө аж ахуйн салбарт гаргасан батлан даалтын эзлэх хувь өсчээ.

- 2016 оны сүүл үеэс эхлэн батлан даалт гаргах дундаж хугацаа өссөн дүнтэй байгаа бөгөөд
- 2020 оны 1 дүгээр улиралд гаргасан батлан даалтын дундаж хугацаа 95.1 сар буюу 7.9 жил байна.

95.1
CAP



Банкны ангиллаар

- Төрийн банк 56.8%
- Капитрон банк 28.4%
- Худалдаа хөгжлийн банк 14.7%

2020 оны 1 дүгээр улиралд Сангаас гаргасан батлан даалтын 56.8 хувийг Төрийн банк, 14.7 хувийг Худалдаа хөгжлийн банк, 28.4 хувийг Капитрон банкны эзэлд гаргасан батлан даалт тус тус бүрдүүлж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА




Гишүүдийн татварын орлого буюу хүүгийн орлого

92.1%

Батлан даалт, хураамж, шимтгэлийн орлого

7.9%



Нийт хөрөнгийн өгөөж



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар чанаргүй батлан даалтын үлдэгдэл 9.4 тэрбум төгрөгт хүрлээ.

Чанаргүй батлан даалтын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 14.6 болж өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өслөө.

- Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 57.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 17.4 хувь нь үйлчилгээний салбарт, 17.2 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 8.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт байна.
- Жил ирэх тусам үйлдвэрлэлийн салбарын чанаргүй батлан даалтын эзлэх хувь багасаж байгаа бол хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарын чанаргүй батлан даалт өссөн байна.



Үйлдвэрлэл




Хөдөө аж ахуй



Бөөний болон жижиглэн худалдаа



Үйлчилгээ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2018.1	2019.1	2020.1
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	2,590.7	2,456.5	2,489.0
ЗЗҮ/ДНБ	8.0%	6.7%	6.7%
Хөрвөх чадвар	0.7%	1.8%	0.4%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	17.7	44.6	9.6
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	0.03	0.1	–
ЗГҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/	24.3	4.9	–
ТОП–20 индекс	21,021.8	20,826.1	16,903.7
MSE А индекс	10,452.2	9,458.5	7,914.1
MSE Б индекс	10,115.2	8,322.0	7,660.2
ХК–ийн тоо	301	307	305
ҮЦК–ийн тоо	53	54	54
ХАА–н биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	42.4	33.1	28.3
МАРІХ	843,906.5	1,085,809.5	794,738.0

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2018.1	2019.1	2020.1
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	258.3	327.6	350.0
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж /тэрбум төгрөг/	35.3	38.3	41.5
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	12.6	12.5	15.6
Нөөц сан /тэрбум төгрөг/	125.6	141.8	157.9
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	12.6	12.5	13.1
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	3.6	5.5	4.6
Мэргэжлийн оролцогчид	2018.1	2019.1	2020.1
Ердийн даатгал	15	15	15
Урт хугацааны даатгал	1	1	1
Давхар даатгал	1	2	1
Даатгалын төлөөлөгч	2,573	2,448	2,488
Даатгалын зуучлагч	43	50	54
Хохирол үнэлэгч	28	26	27
Актуарч	22	30	30
Аудитор	130	141	144
Аудиторын компани	42	43	45

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2018.1	2019.1	2020.1
Нийт хөрөнгө	1,046.8	1,395.5	1,776.8
Эргэлтийн хөрөнгө	1,008.6	1,344.1	1,707.2
Мөнгөн хөрөнгө	264.2	315.8	351.4
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1.8	1.8	9.5
Нийт зээл	706.7	975.5	1,271.5
Хэвийн зээл	590.5	846.2	1,114.6
Хугацаа хэтэрсэн зээл	37.9	40.2	50.7
Чанаргүй зээл	78.3	89.1	106.4
Зээлийн эрсдэлийн сан	59.2	67.4	81.8
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	8.9	10.2	12.5
Эргэлтийн бус хөрөнгө	38.2	51.4	69.6
Нийт өр төлбөр	235.5	334.1	488.3
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	42.2	66.1	115.2
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	126.8	148.5	203.2
Төслийн зээлийн санхүүжилт	16.4	18.1	20.6
Эзэмшигчдийн өмч	811.3	1061.4	1288.4
Хоёрдогч өглөг	0.7	0.8	0.8
Хувьцаат капитал	645.5	832.4	951.5
Хуримтлагдсан ашиг	154.5	211.4	302.3
ББСБ-ын тоо	537	539	540
Үүнээс: УБ хот	461	462	465
Хөдөө, орон нутаг	76	77	75
Харилцагчдын тоо	1,358,693	1,664,902	2,203,682
Нийт орлого	56.8	75.4	101.8
Хүүгийн орлого	47.7	63.4	82.8
Хүүгийн бус орлого	6.9	9.9	16.6
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2.2	2.1	2.4
Нийт зардал	38.6	44.4	60.3
Хүүгийн зардал	4.6	6.0	11.8
Хүүгийн бус зардал	21.3	25.5	33.4
Болзошгүй эрсдэлийн зардал	9.3	8.5	10.2
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.7	0.6	0.6
Цэвэр ашиг	18.2	31.0	41.5

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2018.1	2019.1	2020.1
Нийт хөрөнгө	160.8	211.7	229.5
Эргэлтийн хөрөнгө	157.0	206.9	225.3
Мөнгөн хөрөнгө	33.6	45.2	47.2
Авлага	6.8	7.3	8.2
Эргэлтийн бус хөрөнгө	3.8	4.7	4.3
Үндсэн хөрөнгө /цэврээр/	3.7	4.7	4.0
Биет бус хөрөнгө	0.04	0.04	0.3
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.01	0.01	0.02
Нийт зээл	117.9	157.6	172.9
Хэвийн зээл	106.0	147.6	159.5
Хугацаа хэтэрсэн зээл	6.3	3.9	6.0
Чанаргүй зээл	5.5	6.0	7.4
Өр төлбөр	132.4	179.4	186.3
Хадгаламж	108.0	151.0	159.0
Богино хугацаат зээл	5.4	7.8	3.3
Урт хугацаат өр төлбөр	11.3	7.2	7.5
Бусад богино хугацаат өр төлбөр	7.7	13.5	16.5
Өөрийн хөрөнгө	28.3	32.2	43.2
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	14.7	15.9	18.4
Хоршоологчдын өмч	13.4	16.2	24.7
Хуримтлагдсан орлого /алдагдал/	5.6	7.1	13.0
Нийт орлого	9.8	12.6	14.0
Хүүгийн орлого	9.3	12.1	13.4
Үйл ажиллагааны бусад орлого	0.2	0.3	0.3
Үйл ажиллагааны бус орлого	0.2	0.2	0.3
Нийт зарлага	9.2	12.2	11.8
Хүүгийн зардал	5.3	7.2	7.6
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	1.1	1.3	0.7
Үйл ажиллагааны зардал	2.7	3.4	3.3
Үйл ажиллагааны бус зардал	0.1	0.2	0.03
Цэвэр орлого	0.5	0.4	2.2
ХЗХ–дын тоо	288	282	254
УБ ХЗХ–дын тоо	186	178	160
Орон нутаг ХЗХ–дын тоо	102	104	94
Гишүүдийн тоо /мянга/	57.7	66.3	74.7



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia